

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол улсын иргэдийн Үндсэн хуульд заасан мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага болон нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа мэдээллийг нийтэд нээлттэй байлгах зарчмыг хангах, иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах зорилгоор эдгээр байгууллагад хандаж хүсэлт гаргах, уг хүсэлтийг хүлээн авч барагдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж

2.1.Мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹ энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Төрийн байгууллагын мэдэлд байгаа хуульд нууцад хамааруулахаар зааснаас бусад мэдээлэл болон нийтлэг үйлчилгээ үзүүлдэг

¹ “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 1992 №1

аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа энэ хуулийн 9.2-д заасан мэдээлэл энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамаарна.

3.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль²-ийн 4 дүгээр зүйлд заасан өргөдөл, санал, мэдэгдэл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хууль үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1. Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "мэдээлэл" гэж хүмүүс, биет зүйл, үйл явдал, үзэгдлийн талаархи мэдээг агуулсан мэдээ, баримт бичгийг;

4.1.2. "нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж" гэж боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндийн болон тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарын тодорхой үйлчилгээг хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу нийтэд үзүүлж буй **хувийн** болон **төрийн өмчийн аж ахуйн нэгжийг**.

5 дугаар зүйл. Мэдээлэл нээлттэй байх зарчим

5.1. Төрийн байгууллагын мэдэлд байгаа хуульд нууцад хамааруулхаар зааснаас бусад мэдээлэл болон нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн мэдэлд байгаа энэ хуулийн 9.2-д заасан мэдээлэл нийтэд нээлттэй байна.

6 дугаар зүйл. Нууцад хамаарах мэдээллийн ангилал, агуулга

6.1. Нууцад хамаарах мэдээллийг дараахь байдлаар ангилна:

6.1.1. хувийн;

6.1.2. байгууллагын;

6.1.3. төрийн.

6.2. Хувийн нууцад түүний эрүүл мэнд, гэр бүл, эд хөрөнгө захидал харилцааны нууц хамаарна.

6.3. Байгууллагын нууцад хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйл хамаарна.

6.4. Төрийн нууцад дараахь агуулга бүхий мэдээлэл хамаарна.

² "Төрийн мэдээлэл" эмхэтгэл 1995 №21

6.4.1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл;

6.4.2.Монгол Улсын гадаад бодлого, байр суурьтай холбоотой онц чухал мэдээлэл, түүнчлэн Монгол Улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл;

6.4.3.батлан хамгаалах бодлого, үзэл баримтлал, цэргийн номлолтой холбоотой мэдээлэл;

6.4.4.батлан хамгаалах стратеги, оперативын төлөвлөгөө, түүний биелэлтийн мэдээ, цэргийн стратеги, оператив, дайчилгааны дэлгэн байгуулалт, операци, байлдааныг бэлтгэх, хэрэгжүүлэх байлдааны удирдлагын баримт бичиг, зэвсэгт тэмцэл явуулах арга, байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, дайчилгааны нөөц, түүний ашиглалтын тухай мэдээлэл;

6.4.5.цэргийн зэвсэг техникийг шинээр бий болгох, худалдан авах, боловсронгуй болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил, энэ зорилгоор хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, тэдгээрийн биелэлт, үр дүнгийн талаархи мэдээлэл;

6.4.6.нууц зэвсэг, түүнчлэн техник хэрэгслийн нэр, төрөл, техникийн өгөгдөхүүн, байлдаанд ашиглах боломж;

6.4.7.улсыг батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий объектуудын байрлал, зориулалт, бэлэн байдлын зэрэглэл, хамгаалалт, тэдгээр объектын зураг төсөл, дагалдах баримт бичиг, зардлын төсөв, объект барьж байгуулахаар олгосон газар нутаг, холбогдох бусад мэдээлэл;

6.4.8.зэвсэгт хүчин, бусад цэргийн анги, салбарын зориулалт, зэвсэг, техникийн хангалт.нууцалсан болон тусгай томилгоот байрлал, жинхэнэ нэр, зэвсэглэл, бие бүрэлдэхүүний тооны талаархи мэдээлэл;

6.4.9.Монгол Улсын яам, тусгай газар, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, жилийн тооцоот хэрэгцээний захиалга, төлөвлөгөөтэй холбоотой мэдээлэл;

6.4.10.улсын хилийн хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зохион байгуулалт, арга ажиллагаа, тэдгээрт холбогдох мэдээлэл;

6.4.11.иргэний хамгаалалтын нийтийн дайчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх болон онцгой нөхцөл байдлын үед хүн амын аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, хангалтын объектуудын байрлал, зориулалт, энэ үед дэд бүтцийг ашиглахтай холбогдсон мэдээлэл;

6.4.12.үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, туршилт, нээлт, зураг төсөл, үндэсний болон дэвшилтэт технологийн талаархи мэдээлэл;

6.4.13.цэргийн зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон дайчилгааны хүчин чадал, улсын материаллаг нөөцийн бодит хэмжээ, байрлалын мэдээлэл;

6.4.14.батлан хамгаалах болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий стратегийн түүхий эд, материалын нөөц, олборлолт, нийлүүлэлтийн хэмжээтэй холбоотой мэдээлэл;

6.1.15.төрийн нууцыг хамгаалах арга хэрэгсэл, энэ талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн тухай мэдээлэл;

6.4.16.тагнуул, сөрөх тагнуулын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажлын арга хэлбэр, хүч хэрэгсэл, мэдээллийн эх сурвалж, орон тоо, зохион байгуулалт, баримт бичиг, архив, мэдээллийн сан, санхүүжилтийн тухай мэдээлэл;

6.4.17.төрийн холбооны нууцлал бүхий систем, түүнд холбогдох баримт бичиг, төрийн шифр, түүнийг ашиглах арга, ажиллагааны талаархи мэдээлэл;

6.4.18.цагдаа, тагнуул, хорих байгууллагын галт зэвсэг, тусгай хэрэгслийн хангалт, нөөц, нийтийн эмх замбараагүй байдлын үед тагнуул, цагдаагийн байгууллага, дотоодын цэргийн ажиллах төлөвлөгөө, улсын онц чухал объектын хамгаалалтын хүч хэрэгслийн тухай мэдээлэл, дайны болон дайн бүхий байдлын үед хорих байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох бусад мэдээлэл;

6.4.19.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаархи мэдээлэл;

6.4.20 терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдсон мэдээ, баримт, материалын нууцалбал зохих хэсэг

6.4.21.цаазаар авах ялыг гүйцэтгэхтэй холбогдсон мэдээлэл.

6.5. Нууцад хамаарах мэдээллийн нарийвчилсан жагсаалтыг энэ хуулийн 6 дугаар зүйлийн агуулгад нийцүүлэн хуулиар тусгайлан тогтооно.

7 дугаар зүйл. Мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хэрэгжүүлэх баталгаа

7.1. Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17-д заасны дагуу алив мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

7.2. Монгол Улсын иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхээ эдлэхэд хуульд нууцад хамруулахаар заасан мэдээлэл хамаарахгүй.

7.3. Монгол Улсын хуулийн этгээд мэдээлэл хайх, хүлээн авах асуудлаар Монгол Улсын иргэнтэй адил эрхтэй байна.

7.4. Төрийн байгууллага болон нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж /цаашид “мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага” гэх/ мэдээлэл хайж буй этгээдийг энэ хуульд заасан журмын дагуу мэдээллээр хангах үүрэгтэй.

7.5. Мэдээлэл хайж буй этгээд /цаашид “мэдээлэл хүсэгч” гэх/-ийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг энэ хуулийн 7.2.-т зааснаас бусад үндэслэлээр хязгаарлахыг хориглоно.

7.6. Мэдээлэл хүсэгч тухайн мэдээллийг хайх, хүлээн авах болсон үндэслэл, шаардлагаа тайлбарлах үүрэггүй байна.

7.7. Мэдээлэл хүсэгч мэдээлэл хайх, хүлээн авах хэлбэрээ сонгох, мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх, мэдээллийн агуулгыг амаар тайлбарлуулах, нэмэлт лавлагаа гаргуулах эрхтэй.

7.8. Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүн, гадаад улсын болон олон улсын байгууллага нь мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллагаас энэ хуульд заасан журмын дагуу мэдээлэл авах эрхтэй байна.

8 дугаар зүйл. Мэдээллээр хангах үүрэг бүхий төрийн байгууллагын ангилал

8.1. Мэдээллээр хангах үүрэг бүхий төрийн байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу дараахь байдлаар ангилна.

8.1.1.төрийн байгууллага;

8.1.2. албан газар;

8.2. Энэ хуулийн 8.1.1.-д заасан төрийн байгууллагад дараахь байгууллага хамаарна.

8.2.1.Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газар;

8.2.2.Монгол Улсын Яам;

8.2.3.Засгийн газрын хэрэг эрхлэх газар;

8.2.4.Засгийн газрын агентлаг;

8.2.5.Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг бусад байгууллага;

8.2.6.Монгол Улсын Яам, Засгийн газрын агентлагийн харъяа бусад байгууллага;

8.2.7.аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал;

8.2.8.аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний харъяа байгууллага;

8.2.9.Үндэсний хороо, комисс, зөвлөл, тэдгээрийн ажлын алба.

8.3. Энэ хуулийн 8.1.2.-т заасан албан газарт улсын төсвөөс санхүүждэг эмнэлэг, сургууль /их, дээд, тусгай мэргэжлийн болон ерөнхий боловсролын/ хүрээлэн, академи, театр, музей эдгээртэй адилтгах бусад байгууллага хамаарна.

8.4. Энэ хуулийн 8.2.-т заасан төрийн байгууллагын дэлгэрэнгүй жагсаалт болон 8.3.-д заасан албан газрын жагсаалтыг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

8.5. Нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийг дараахь байдлаар ангилна.

8.5.1. төрийн өмчит үйлдвэрийн газар;

8.5.2. хувийн өмчийн аж ахуйн нэгж.

8.6. Энэ хуулийн 8.5.-д заасан нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжийн жагсаалтыг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

9 дүгээр зүйл. Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллагаас өгөх мэдээллийн бүтэц, мэдээлэл өгөх үүрэг

9.1. Энэ хуулийн 8.1.-д заасан төрийн байгууллага мэдээлэл хүсэгчийг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан мэдээллээр хангах үүрэгтэй.

9.2. Энэ хуулийн 8.5.-д заасан нийтлэг үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж мэдээлэл хүсэгчийг зөвхөн дараахь мэдээллээр хангах үүрэгтэй.

9.2.1. өөрийн нь явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл;

9.2.2. өөрийн нь мэдэлд байгаа хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд

аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээлэл.

10 дугаар зүйл. Мэдээллийн ажилтан

10.1.Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлхийн тулд ийм үүрэг бүхий мэдээллийн ажилтантай байна.

10.2. Мэдээллийн ажилтны үүрэг .

10.2.1 . мэдээлэл хүсэгчээс ирүүлсэн хүсэлтийг бүртгэн авах;

10.2.2. мэдээлэл хүсэгчийн хүссэн хэлбэрээр тухайн мэдээллийг аль болох шуурхай өгөх арга хэмжээ авах;

10.2.3.мэдээлэл хүсэгчид энэ хуульд заасны дагуу зөвлөлгөө өгөх, туслалцаа үзүүлэх ;

10.2.4. мэдээлэл авах тухай хүсэлтийг хэрхэн барагдуулсан тухай мэдээг улирал бүр гаргаж дараа улирлын эхний сард, тайланг жил бүр гаргаж, дараа оны эхний улиралд багтаан Хүний эрхийн үндэсний комиссд хүргүүлэх

10.2.5. энэ хуульд заасан бусад.

10.3. Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага ажлын цар хүрээ, онцлогоосоо хамааран мэдээллийн ажилтнаараа өөр чиг үүрэг хавсран гүйцэтгүүлэх буюу шаардлагатай гэж үзвэл уг үүргийг эрхлэн гүйцэтгэх хэд хэдэн ажилтантай байж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЭЛ ХАЙХ, ХҮЛЭЭН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

11 дүгээр зүйл. Мэдээлэл авах тухай хүсэлт гаргах журам

11.1.Хүсэлт гаргагч авах гэж буй мэдээллийнхээ тухай бичгээр хүсэлт гаргана. Ингэхдээ тухайн мэдээлэл мэдэлд нь байгаа байгууллагад хандаж уг хүсэлтийг гаргах ба хэрэв хүсч буй мэдээлэл нь тухайн байгууллагын мэдэлд байхгүй, эрх хэмжээнд нь хамааралгүй бол уг байгууллага мэдээлэл өгөх үүрэг хүлээхгүй.

11.2. Бичгээр гаргаж буй хүсэлт дараахь хэлбэртэй байж болно.

11.2.1. цахим /электрон/ ;

11.2.2. бичмэл ;

11.2.3. бусад боломжтой хэлбэрээр.

11.3. Хүсэлт гаргагч авах гэж буй мэдээллийнхээ агуулга болон хариу хүлээн авах хэлбэрийг ойлгомжтой тодорхойлохын гадна нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, хүсэлт гаргасан огноог дурдсан байна.

11.4. Мэдээлэл авах тухай хүсэлтийг монгол хэлээр гаргах бөгөөд хэрэв өөр хэлээр /казах эсхүл гадаадын иргэн эх хэлээрээ/ гаргасан бол түүнийг монгол хэлрүү орчуулж хавсаргана.

11.5. Мэдээлэл авах тухай хүсэлтийг хэд хэдэн этгээд хамтран гаргаж болох бөгөөд тэдгээрт энэ хуулийн 11.3.-т заасан зохицуулалт нэг адил хамаарна.

11.6. Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага хүсэлт гаргагчид энэ хуулийн 11.3,11.4-д зааснаас бусад шаардлага тавихыг хориглоно.

12 дугаар зүйл. Мэдээлэл хүлээн авах хэлбэр

12.1.Мэдээлэл хүсэгч дараахь хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй байна:

12.1.1.баримт бичгийг цаасан болон цахим /электрон/ хэлбэрээр хуулбарлан авах;

12.1.2.хүсч буй мэдээлэлтэй холбоо бүхий баримт бичиг, биет зүйл, байгаа байдалтай танилцах;

12.1.3. нийтийн болон цахим /электрон/ шуудангаар хүлээн авах;

12.1.4. холбооны хэрэгсэл ашиглан авах;

12.2. Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага боломжтой гэж үзсэн тохиолдолд энэ хуулийн 12.1-д зааснаас бусад хэлбэрээр мэдээлэл авч болно.

13 дугаар зүйл. Мэдээлэл авах тухай хүсэлтийг бүртгэх, шилжүүлэх

13.1.Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага нь мэдээлэл хүсэгчтэй уулзах, мэдээлэл авах тухай хүсэлт хүлээн авах, байрыг тусгайлан бэлтгэж, цагийн хуваарь тогтоон, нийтэд харагдахаар газарт байршуулна.

13.2. Мэдээллийн ажилтан /эсхүл бичиг хэрэг/ мэдээлэл авах тухай хүсэлтийг хүлээн авмагц уг мэдээлэл тухайн байгууллагын мэдэлд байгаа эсэхийг сайтар тодруулсны эцэст бүртгэн авч, хүлээн авсан өдөр, цагийг тэмдэглэн өдөрт нь багтаан холбогдох албан тушаалтанд шилжүүлнэ.

13.3.Хэрэв уг мэдээлэл тухайн байгууллагын мэдэлд байхгүй буюу эрх хэмжээнд нь хамааралгүй бол уг асуудлаар мэдээлэл өгөх үүрэггүй болохыг хүсэлт гаргагчид тайлбарлаж, мэдээлэл байгаа газрыг зааж өгнө. Хэрэв тухайн мэдээлэл байгаа газрыг мэдэхгүй бол байж болох буюу ижил төсөөтэй мэдээлэл бүхий бусад эх сурвалжийн талаар тайлбарлаж өгнө.

13.4.Хүсэлт гаргагч хараагүй, хэлгүй, дүлий зэрэг шалтгааны улмаас харилцаж чадахгүй, эсхүл монгол хэл мэдэхгүй бол хэлмэрч, орчуулагчаараа дамжуулан хүсэлт гаргах бөгөөд уг хүсэлтийг мэдээллийн ажилтан тэмдэглэн авч түүний нэг хувийг хүсэлт гаргагчид өгнө.

13.5. Хүсэлт гаргагч авах гэж буй мэдээллийнхээ агуулгыг ойлгомжтой тодорхойлоогүй тохиолдолд уг хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болох ба хэрхэн тодруулах талаар мэдээллийн ажилтан түүнд сайтар зөвлөж туслана.

14 дугаар зүйл. Мэдээлэл хүсэгчид хариу өгөх

14.1.Мэдээлэл хүсэгчид авах гэж буй мэдээллийн нь талаар ажлын 10 хоногт багтаан хариу өгнө.

14.2.Хариу өгөх хугацааг уг хүсэлтийг хүлээн авч бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

14.3. Уг мэдээллийг гаргахад нэмэлт ажиллагаа шаардагдахаар бол энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэх ба энэ хуулийн 14.1.-д заасан хугацаа дууссанаас хойш 10 хоногийн дотор хариу өгч болно.

14.4. Дараахь тохиолдолд нэмэлт ажиллагаа хийнэ:

14.4.1.хүсэлт гаргагчаас нэмэлт мэдээлэл авах шаардлага гарсан;

14.4.2. хүсэлтэд дурдсан мэдээллийг гаргахад энэ хуулийн 15.4.-д заасан ердийн боломжит хэмжээнээс их зардал гарахаар бол.

15 дугаар зүйл. Мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал

15.1. Хуульд өөрөөр заагаагүй бол хүсэлт гаргагчид өгч буй мэдээлэл төлбөргүй /үнэгүй/ байна.

15.2. Төлбөртэй байхаар хуульд тусгайлан заасан мэдээлэлд энэ хуулийн 15.1. хэсэгт заасан зохицуулалт хамаарахгүй.

15.3.Хуульд тусгайлан заагаагүй боловч тухайн мэдээллийн онцлог, ач холбогдол зэргийг харгалзан хүсэлт гаргагчийн саналаар харгалзан, тодорхой төрлийн мэдээллийг төлбөртэй өгч болно. Төлбөртэй өгч болох мэдээллийн төрөл, төлбөрийн хэмжээг Хүний эрхийн Үндэсний комисс тогтоох ба төлбөрийн хэмжээ тухайн мэдээллийг бэлтгэх, хувилах, хүргэхэд гарах зардлаас хэтрэхгүй байна.

15.4.Мэдээлэл хүсэгчид өгөх мэдээллийг хувилах, хүргэх ажиллагаанд шаардагдах ердийн боломжит зардал /20 хуудсаас илүүгүй/ -ыг мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага хариуцна.

15.5. Хэрэв хүсэлтэд дурдсан мэдээллийг бэлтгэх, хувилах, хүргэх ажиллагаанд ердийн боломжит хэмжээнээс их зардал гарахаар бол илүү гарсан хэсгийг мэдээлэл хүсэгч хариуцна.

15.6. Энэ хуулийн 15.5-д заасан тохиолдолд уг хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын гурав хоногт багтаан энэ тухай хүсэлт гаргагчид мэдэгдэх ба дараахь агуулга бүхий зардлын мэдэгдэл хүргүүлнэ:

15.6.1. хүсэлт гаргагчийн төлбөл зохих зардлын хэмжээ;

15.6.2. зардлын төрөл, анги

15.6.3.уг зардлыг төлөх хэлбэр.

15.7.Хүсэлт гаргагч нь зардлын мэдэгдэл хүлээн авснаас хойш 1 сарын дотор уг зардлыг төлнө.

15.8.Зардлын мэдэгдлийн загварыг Хүний эрхийн үндэсний комисс батална.

16 дугаар зүйл. Мэдээлэл хүсэгчид туслах, зөвлөх

16.1.Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага хүсэлт гаргагчид дараахь хэлбэрээр туслалцаа үзүүлж, зөвлөгөө өгөх үүрэгтэй:

16.1.1. мэдээлэл өгөх ерөнхий хугацаа болон уг мэдээллийг ямар хэлбэрээр авах хүсэлт гаргаснаас шалтгаалан өгч болох хамгийн боломжит богино хугацааг тайлбарлаж өгөх;

16.1.2. мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал, төлбөр хийгээд түүнийг төлөх журам, зардлын мэдэгдлийн агуулгыг ойлгуулах.

16.1.3. энэ хуульд заасан бусад

17 дугаар зүйл. Мэдээлэл авах тухай хүсэлтийг барагдуулах

17.1. Мэдээлэл авах тухай хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан дараахь арга хэмжээний аль нэгийг авна:

17.1.1. бичгийн хэлбэрээр хариу өгөх шаардлагатай мэдээллийг аль болох шуурхай бэлтгэж, энэ хуульд заасан хугацаанд хүсэлт гаргагчид хүргүүлэх ;

17.1.2.мэдээлэл хүсэгч тодорхой мэдээлэлтэй танилцах хүсэлт гаргасан бол танилцах боломжоор тэр даруй хангах;

17.1.3.мэдээлэл хүсэгч тодорхой мэдээлэл хуулбарлан авах хүсэлт гаргасан бөгөөд уг мэдээлэл бэлэн байгаа тохиолдолд тэр дор нь хуулбарлан өгөх;

17.1.4. мэдээлэл хүсэгч тодорхой биет зүйлийн байгаа байдалтай танилцах хүсэлт гаргасан бол уг зүйлийг тэр даруй биечлэн үзүүлэх.

17.2. Уг мэдээлэл нь тухайн байгууллагын мэдэлд байхгүй буюу эрх хэмжээнд нь хамааралгүй бол холбогдох байгууллагад ажлын 3 хоногт багтаан шилжүүлж, энэ тухай хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

17.3. Холбогдох албан тушаалтан энэ хуулийн 18.1-д заасан үндэслэлээр мэдээлэл өгөхөөс татгалзаж болох ба энэ тухай хүсэлт гаргагчид мөн бичгээр мэдэгдэнэ.

17.4. Мэдээлэл авах тухай хүсэлтэд хариу өгсөн он, сар, өдөр, бэлтгэсэн албан тушаалтны нэр, мэдээлэл өгсөн хэлбэр зэргийг уг хүсэлтийг хүлээн авсан бүртгэлд тэмдэглэж хадгална.

18 дугаар зүйл. Мэдээлэл өгөхөөс татгалзах

18.1.Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага дараахь үндэслэлээр мэдээлэл өгөхөөс татгалзаж болно:

18.1.1.уг мэдээлэл тухайн байгууллагын мэдэлд байхгүй бөгөөд энэ хуулийн 17.2.-т заасны дагуу шилжүүлэх боломжгүй бол;

18.1.2. уг мэдээлэл тухайн байгууллагын мэдэлд байгаа боловч хүсэлтэд дурдсан хэлбэрээр өгөх боломжгүй бол;

18.1.3.уг мэдээллийг нийтэд зориулан нэгэнт хэвлэн гаргасан буюу тухайн хүсэлт ирснээс хойш нэг сарын дотор хэвлэн нийтлэхээр бэлтгэж байгаа бол;

18.1.4. мэдээлэл авахтай холбогдон гарах боломжит хэмжээнээс илүү гарсан зардлыг хүсэлт гаргагч энэ хуулийн 15.4-т заасан хугацаанд төлөөгүй бол;

18.1.5.хүсэлт гаргагч уг мэдээллийг авахаар 1 жилийн дотор дахин хүсэлт гаргасан бол;

18.1.6.уг мэдээллийг нууцад хамруулахаар холбогдох хуульд заасан бол;

18.1.7.энэ хуулийн 23.2-т заасан зөршөөрлийг холбогдох этгээдээс аваагүй бол.

18.2.Мэдээлэл өгөхөөс татгалзах тохиолдолд үндэслэлээ тодорхой заасан мэдэгдлийг мэдээлэл хүсэгчид хүргүүлнэ.

18.3.Мэдээлэл өгөхөөс татгалзах тохиолдолд мэдээлээр хангах үүрэг бүхий байгууллагын энэ хуульд заасан мэдээлэл хүсэгчид туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх үүрэг хэвээр байна.

19 дүгээр зүйл. Мэдээлэл өгөх боломжгүй байдал

19.1. Мэдээлэл хүсэгчийн авах гэж буй мэдээлэл Архивын тухай хуульд заасны дагуу төрийн архивт шилжсэн бол үүнийг мэдээлэл өгөх боломжгүй байдал гэж үзнэ. Энэ тохиолдолд мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага мэдээлэл хүсэгчид энэ тухай бичгээр мэдэгдэж, хувийг нь тухайн архивт заавал хүргүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Тодорхой төрлийн мэдээлэлтэй холбоотой онцлог зохицуулалт

20 дугаар зүйл . Мэдээллийн сан

20.1.Холбогдох хуульд заасан журмын дагуу бүрдүүлсэн мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээлэл нийтэд нээлттэй байна.

20.2. Хуульд нууцад хамааруулахаар заасан мэдээлэл тухайн санд байгаа бол түүнд энэ хуулийн 20.1. хэсэгт заасан зохицуулалт хамаарахгүй.

20.3.Мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага өөрийн мэдэлд байгаа мэдээллийн санд хадгалагдаж буй мэдээллийн төрөл, агуулгын талаар нийтэд мэдээллэх үүрэгтэй.

21дүгээр зүйл. Төрийн нууцаас гарсан мэдээлэл

21.1.Төрийн нууцад хамааруулах хугацаа дууссан буюу хуульд заасан бусад үндэслэлээр төрийн нууцаас гарсан мэдээллийг гарсан даруйд нь нийтэд нээлттэй болгоно.

21.2.Энэ хуулийн 22.1-д заасан мэдээлэл мэдэлд нь байгаа төрийн байгууллага улирал тутам нууцаас гарсан мэдээллийн жагсаалтыг гаргаж, тэдгээрийн эх сурвалжийн талаархи мэдээллийн хамт хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

21.3.Нууцаас гарсан асуудлаар мэдээлэл авахад энэ хуулийн хоёрдугаар бүлэгт заасан журмыг баримтална.

22 дугаар зүйл. Төрийн архивын сан хөмрөгийн мэдээлэл

22.1.Төрийн архивын сан хөмрөгөөс мэдээлэл авахад энэ хуулийн хоёрдугаар бүлэгт заасан журмыг баримтална.

22.2.Төрийн архивын сан хөмрөгт гэрээний үндсэн дээр хадгалуулсан мэдээллийг тухайн мэдээллийн өмчлөгчийн зөвшөөрлийг үндэслэн мэдээлэл хүсэгчид өгч болно.

22.3.Төрийн архив нь төрийн архивын сан хөмрөгөөс мэдээлэл өгөх зориулалт бүхий уншлагын танхимтай байна.

22.4.Уншлагын танхимд тавих стандартыг архивын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

23 дугаар зүйл. Гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болзошгүй мэдээлэл

23.1.Дараахь мэдээллийг гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болзошгүй мэдээлэл гэж үзнэ:

23.1.1.төрийн байгууллага, албан тушаалтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс авсан тэдгээрийн **хувийн** болон **арилжааны** нууцад хамаарах мэдээлэл;

23.1.2.төрийн байгууллага албан тушаалтанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл,гомдол, хүсэлт;

23.1.3.төрийн албан хаагчаас өөрийн болон холбогдох бусад төрийн байгууллагад гаргасан хувийн өргөдөл, хүсэлт;

23.1.4.мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллагын мэдэлд байгаа хувь хүний нууцад хамаарах бусад мэдээлэл.

23.2.Гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж болзошгүй мэдээллийг зөвхөн уг этгээдийн зөвшөөрлөөр хүсэлт гаргагчид өгч болно.

24 дүгээр зүйл. Түүхэн мэдээлэл

24.1.Энэ хуулийн 23.1-д заасан мэдээлэл үүссэнээс хойш 60 жил өнгөрсөн бол түүнийг түүхэн мэдээлэлд хамааруулна.

24.2.Түүхэн мэдээлэл нийтэд нээлттэй байна.

24.3.Түүхэн мэдээлэлд хамаарах асуудлаар мэдээлэл авахад энэ хуулийн хоёрдугаар бүлэгт заасан журмыг баримтална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мэдээллийг хэвлэн нийтэлж түгээх үүрэг

25 дугаар зүйл. Төрийн байгууллагын нийтэд мэдээлэл түгээх үүрэг

25.1.Эрх бүхий төрийн байгууллага дараахь мэдээллийг нийтэд хэвлэн нийтэлж түгээх үүрэгтэй:

25.1.1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр;

25.1.2.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, бусад шийдвэрийн төсөл;

25.1.3.Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлагын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр;

25.1.4.Улсын Их Хурал, Засгийн газрын хуралдааны дэг, Засгийн газар, түүний гишүүд, Засаг даргын дэргэдэх зөвлөл, тэдгээртэй адилтгах орон тооны ба орон тооны бус хороо, зөвлөлийн ажиллах журам;

25.1.5.Улсын Их Хурлын хуралдааны тэмдэглэлтэй танилцах журам;

25.1.6.гадаад, дотоодоос авсан хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлж буй төслийн тайлан;

25.1.7. хууль тогтоомж, бусад шийдвэрийн төсөлд санал өгөх журам;

25.1.8.иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаархи тухайн байгууллагын дотоод журам;

25.1.9.төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг;

25.1.10.хуульд заасны дагуу хэвлэн нийтлэх хэлбэрээр нийтэд түгээх шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

25.2. Хуульд заасан бол энэ хуулийн 25.1-д заасан мэдээллийг хуульд тусгайлан заасан хэвлэлд нийтлэх буюу нийтэд хүртээмжтэй харилцаа холбооны бусад /цахим сүлжээ гэх мэт/ хэрэгслийг ашиглах замаар түгээнэ.

25.3.Эрх бүхий төрийн байгууллага энэ хуулийн 25.1-д заасан мэдээллийг хэвлэн нийтлэх зардлыг тухайн жилийн төсөвтөө тусгана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

26 дугаар зүйл. Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт

26.1.Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд Хүний эрхийн Үндэсний комисс /цаашид “комисс” гэх/ хяналт тавьж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.

27 дугаар зүйл. Гомдол гаргах

27.1.Мэдээлэл хүсэгч мэдээллээр хангах үүрэг бүхий байгууллага өөрийн нь мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг зөрчсөн гэж үзвэл тухайн байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд гомдол гаргана.

27.2.Энэ хуулийн 27.1-д заасан гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Давж заалдах

28.1.Энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу гаргасан гомдлыг холбогдох байгууллага, албан тушаалтан шийдвэрлээгүй буюу эсхүл тэдгээрээс гаргасан шийдвэрийг тухайн хүсэлт гаргагч хүлээн зөвшөөрөөгүй бол Хүний эрхийн Үндэсний комиссд давж заалдана.

28.2.Давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг баримтална.

28.3.Мэдээлэл хүсэгч Хүний эрхийн Үндэсний комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй бол Захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргах эрхтэй.

29 дүгээр зүйл. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

29.1.Энэ хуулийн 9,13 дугаар зүйлд заасныг зөрчсөн байгууллагыг 200000-250000 төгрөгөөр, албан тушаалтныг 15000-30000 төгрөгөөр торгох шийтгэлийг шүүгч ногдуулна.

30 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

34.1.Энэ хуулийг 2009 оны ... дүгээр сарын ... -ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто замын тухай хуульд дараахь агуулга бүхий 16 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг нэмсүгэй:

“16.3.Авто замын мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТАН УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО, ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд дараахь агуулга бүхий 7 дугаар зүйлийн 1 дахь хэсгийн 4¹ дэх заалт нэмсүгэй:

“7.1.4¹. Монгол Улсын хилээр нэвтэрсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мэдээлэл авах эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ АЙМГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Амьтны аймгийн тухай хуульд дараахь агуулга бүхий 18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг нэмсүгэй:

“18.3. Амьтны аймгийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АХУЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуульд дараахь агуулга бүхий 17 дугаар зүйлийн 4 дэхь хэсгийг нэмсүгэй:

“18.3. Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд дараахь агуулга бүхий 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5¹ дэх заалтыг нэмсүгэй:

“11.1. 5¹.Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд дараахь агуулга бүхий 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5 дугаар заалт нэмсүгэй:

“7.5.5. Үнэлгээний мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгалийн ургамлын тухай хуульд дараахь агуулга бүхий 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нэмсүгэй:

“5.3.Ургамлын нөөцийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуульд дараахь агуулга бүхий 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 4¹ дэх нэмсүгэй:

“9.3.4¹. Биеийн тамир, спортын улсын мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын зээл, тусламжийг зохицуулах хуульд дараахь агуулга бүхий 22 дугаар зүйлийн 4 дэх нэмсүгэй:

“22.4. Гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд дараахь агуулга бүхий 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6¹ дэх заалт нэмсүгэй:

“6.1.6¹. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалтын талаархи мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуульд дараахь агуулга бүхий 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7¹ дэх заалт нэмсүгэй:

“24.1.7¹. Гамшгийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

КАДАСТРЫН ЗУРАГЛАЛ БА ГАЗРЫН КАДАСТРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд дараахь агуулга бүхий 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7¹ дэх заалт нэмсүгэй:

“3.1.7¹. Кадастрын зураглалын мэдээллийн сан сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууц хувьчлах тухай хуульд дараахь агуулга бүхий 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1/1 дэх заалт нэмсүгэй:

“11.1/1¹. Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд орон сууцны хувьчлалд хамаарах төрийн өмчийн орон сууцны байшин, сууцны мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ОРОН СУУЦНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны тухай хуульд дараахь агуулга бүхий 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт нэмсүгэй:

“7.1.6. орон сууцны мэдээллийн нэгдсэн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуульд дараахь агуулга бүхий 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9¹ дахь заалт нэмсүгэй:

“3.1. 9¹. ойн мэдээллийн нэгдсэн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ПАТЕНТИЙН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Патентийн тухай хуульд дараахь агуулга бүхий 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4¹ дахь заалт нэмсүгэй:

“26.1.4¹. шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдээллийн нэгдсэн нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

РАШААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Рашааны тухай хуульд дараахь агуулга бүхий 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг нэмсүгэй:

“5.2. Рашааны тухай мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд дараахь агуулга бүхий 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт нэмсүгэй:

“6.1.4. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд дараахь агуулга бүхий 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг нэмсүгэй:

“11.5. Үндэсний мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

СОГТУУРУУЛАХ УНДАА ХЭТРҮҮЛЭН ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ АЛБАДАН ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сogтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд дараахь агуулга бүхий 12 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг нэмсүгэй:

“12.7. Мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд дараахь агуулга бүхий 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6¹ дахь заалт нэмсүгэй:

“7.5.6¹. аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд дараахь агуулга бүхий 30 дугаар зүйлийн 11 дэх хэсгийг нэмсүгэй:

“30.11.Тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн нэгдсэн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд дараахь агуулга бүхий 17 дугаар зүйлийн 5 дэх хэсгийг нэмсүгэй:

“17.5. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд дараахь агуулга бүхий 51 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийг нэмсүгэй:

“51.11. Тэндерт оролцогчдын бүртгэлийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хуульд дараахь агуулга бүхий 12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 10¹ дэх заалт нэмсүгэй:

“12.4.10¹.Төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд дараахь агуулга бүхий 14 дүгээр зүйлийн 3 дэх хэсгийг нэмсүгэй:

“14.3. Ус цаг уур, орчны шинжилгээний мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд дараахь агуулга бүхий 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг нэмсүгэй:

“5.7. Усны мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд дараахь агуулга бүхий 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт 6¹ нэмсүгэй:

“16.3.6¹. Хүүхдийн эрхийн талаархи мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүнсний тухай хуульд дараахь агуулга бүхий 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дахь заалт нэмсүгэй:

“12.3.7.Хүнсний аюулгүй байдлын талаархи мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд дараахь агуулга бүхий 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7¹ дахь заалт нэмсүгэй:

“6.1.7¹.химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах үйл ажиллагааны мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд дараахь агуулга бүхий 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5¹ дахь заалт нэмсүгэй:

“8.1.5¹. шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуульд дараахь агуулга бүхий 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9¹ дэх заалт нэмсүгэй:

“9.1.9¹. тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭД ХӨРӨНГӨ ӨМЧЛӨХ ЭРХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭД ХӨРӨНГИЙН БУСАД ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд дараахь агуулга бүхий 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5¹ дэх заалт нэмсүгэй:

“11.1.5¹. эрхийн улсын бүртгэлийн талаархи мэдээллийн сан нийтэд нээлттэй байна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2008 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 хэсэгт дараахь агуулга бүхий 13.2.7 заалт нэмсүгэй:

“13.2.7¹. Мэдээлэл авах эрхийн тухай хуулийн.32.1.-д заасны дагуу гаргасан давж заалдах гомдлыг хүлээн авч шийдвэрлэх”

2 дугаар зүйл. Энэ хуулийг “Мэдээлэл авах эрхийн тухай” хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.